

**ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

2010.03.18

(2009 оны үйл ажиллагааны үр дүн)

№	Үзүүлэлт	Үр дүнгийн үнэлгээ		
		хувь	оноо	
1	Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	1.Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт	88.79%	4.44
		2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	34.69%	5.00
		3.Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт	91.60%	4.58
Үнэлгээний дундаж оноо 4.67				
2	Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ	1.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт	95.0%	4.75
		2.Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт	89.1%	4.45
		3.Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт	100.0%	5.00
		4.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	34.07%	5.00
Үнэлгээний дундаж оноо 4.80				
3	Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ	1.Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	95.8%	4.79
		2.Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	100.0%	5.00
Үнэлгээний дундаж оноо 4.89				
4	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	1. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	92.86%	4.64
		2. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	91.67%	4.58
		3. Төсөв, санхүүгийн ил тод байдал	94.29%	4.71
		4. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал	99.00%	4.95
Үнэлгээний дундаж оноо 4.72				
5	Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	1.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ		4.78
		2.Хэрэглэгчийн үнэлгээ	94.4%	4.72

Үнэлгээний дундаж оноо
4.75

Ерөнхий үнэлгээ	95.32%	4.766
------------------------	---------------	--------------

---oOo---

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2009 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

I. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ҮР ДҮН

Монгол улсын Засгийн газрын 2008-2012 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний аймгийн Засаг дарга, ЗДТГ-т хамааралтай заалтыг ханган биелүүлэхэд, Дэлхийн эдийн засгийн хямрал манай улсын эдийн засагт нөлөөлж буй хүндрэлтэй цаг үе тулгарч байгаа хэдий ч өмнөх сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд бий болгосон ажлын амжилтууддаа тулгуурлан нөөц бололцоогоо бүрэн дайчилж аймгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулах, ялангуяа хувийн хэвшлийг дэмжин ажлын байрууд шинээр бий болгож, ажилгүйдэл ядуурлыг бууруулах, үйлдвэрлэл үйлчилгээг өргөжүүлж эдийн засгийн өсөлтийг түргэтгэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны чадавхийг дээшлүүлж, иргэдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай, хүртээмжтэй хүргэхэд бүх шатны Засаг дарга, Засаг даргын Тамгын Газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг агентлагуудын ажлыг чиглүүлэн зохион байгуулж ирлээ.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол улсын Засгийн газрын 2008-2012 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний холбогдох заалтуудыг бүрэн тусгаж төлөвлөв.

Монгол улсын Засгийн газраас 2009 оныг “Үйлдвэрлэлийг дэмжих жил” болгон зарласан билээ. Төв аймаг 2009 оныг “Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих жил” болгон зарлаж, сум бүрд 17.0 сая төгрөг, Зуунмод суманд 91.0 сая төгрөгийн эх үүсвэртэй үйлдвэрлэлийг дэмжих сан байгуулж үйлдвэрлэл үйлчилгээг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүллээ.

Сум дундын отрын бүс нутгийн хамгаалалт, ашиглалтыг сайжруулах аймгийн бодлого гарган хэрэгжүүлж, Малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн нийт 1548 га-д тариалалт хийж, ногоон тэжээл 3230.0 тн-ыг хураан авч, мал эмнэлгийн анхан шатны нэгжийн үйл ажиллагааг дэмжин, улсын стандартыг 64 мал эмнэлгийн нэгжээр хангуулж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 20 нэр төрлийн арга хэмжээнд 1.8 сая мал, угаалга тарилга туулгалтанд 2.2 сая мал хамруулж, улсын төсвийн хөрөнгөөр 6 худаг, Бүс нутгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтаар 42 худаг, иргэд малчид, төсөл хөтөлбөрийн дэмжлэгээр нийт 26 худаг шинээр болон засварлуулан, 2678.1 мянган га бэлчээр усжуулж, бэлчээр усжуулалтыг 49.49 %-д хүргэсэн нь аймгийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн гол салбар болох Мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах нэг гол хүчин зүйл болж байна.

“Атрын гурав дахь аян”-ы хүрээнд иргэн, аж ахуйн нэгжүүд шинээр талбай эзэмшсэнээр 2008 оноос газар тариалан эрхэлдэг аж ахуй нэгж, иргэдийн тоо 167, талбайн хэмжээ 32804.7 га-аар нэмэгдлээ.

Газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа 1612 өрх, аж ахуйн нэгж нийт 44052 га-д үр тариа, 3454 га-д төмс, 1061 га-д хүнсний ногоо тариалж, үр тариа 66995 тн, төмс 40068 тн, хүнсний ногоо 10960.2 тн-ыг хураан авлаа.

Мах, сүү болон бусад ашиг шимийн чиглэлийн мал, амьтад үржүүлдэг аж ахуй, фермер энэ онд Сүүний үхрийн-146, махны үхрийн-8, гахайн-36, шувууны-28, туулайн-2, зөгийн-9, мах ноосны хонины-1, нийт 230 фермер аж ахуй эрхэлж, нэгжийн ашиг шимийн гарц, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлснээр хөдөлмөрийн бүтээмж дээшилж, малчдын ахуй амьдрал дээшилж байна.

2009 онд сум бүрийг Агропарктай болгосны үр дүнд хамгаалагдсан хөрсний аж ахуй эрхлэх талбайн хэмжээ 56.0 мянган кв метрт хүрч, иргэд нарийн ногоо тарих арга технологид суралцан, 226.4 тн ургац хураан авлаа.

2009 онд 620 тн-ны багтаамжтай 25 зоорь шинээр баригдаж, төмс хүнсний ногоо хадгалах 19246 тн-ны багтаамж бүхий 1641 зоорь ашиглагдаж, 48 худаг шинээр гаргаж 2678.1 мянган га бэлчээр усжуулагдлаа.

Аймгийн эдийн засгийн гол салбар хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд мэдэгдэхүйц өсөлт гарснаар аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 172.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 22.8 хувиар өсөхөөр тооцогдож байна.

Монгол улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг иргэд олон түмэн, байгууллага хамт олны хичээл зүтгэлийг нэгтгэн зохион байгуулж ажилласны үр дүнд манай аймаг өнгөрсөн онд улсын хэмжээний үр тарианы 20.9-ийг үйлдвэрлэж, аймгийнхаа гурилын хэрэгцээг бүрэн хангахуйц 25684 тн буудайг гурилын үйлдвэрт тушааж, төмсний хэрэгцээг 5 дахин, хүнсний ногооны хэрэгцээг 1.4 дахин илүү хангаж, 2012 онд хүрэхээр дэвшүүлсэн зорилтоо давуулан биелүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд 9.8 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил хийгдэж, ЖДҮ-ийг хөгжүүлэх чиглэлээр 1.1 тэрбум төгрөгийн зээл олгож, орон нутагт Жижиг дунд үйлдвэрүүд нэмэгдэн байгуулагдаж байна. Мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангаж ажилласнаар энэ онд 1.2 сая төл бойжуулж, малын тоо толгойг 3.4 саяд хүргэн өсгөлөө. Хөдөө аж ахуйн салбарт олсон дээрх амжилтуудын үр дүнд Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2 дахин нэмэгдсэн дүн гарч байна.

II. 2009 ОНЫ АЙМГИЙН БОДЛОГЫН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Аймгийн ИТХ-ын 2 дугаар хуралдаанаар батлагдсан аймгийн Засаг даргын 2009-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 6 бүлэг, 227 зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийг боловсруулан 199 зорилт 486 арга хэмжээтэйгээр батлуулж явцад нь улирал бүр хяналт-шинжилгээ хийж, эрчимжүүлэх арга хэмжээ авч ирлээ.

“Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих жил”-ийн ажил аймгийн ИТХТ-ийн 19-р хуралдаанаар 97%-тай дүгнэгдэж, аймгийн Засаг даргын 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 227 зорилтын 13 нь хугацаа болоогүй, 1 нь бүрэн биелсэн, 3 нь 90%, 8 нь 70%, 29 нь 50%, 159 нь 30%, 14 нь 10%, аймгийн дүнгээр 34.07%-тай хэрэгжиж байна.

2009 онд аймгийн ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хуралдаанаар “Газрыг үр ашигтай, зохистой ашиглуулах, эзэмшүүлэх, хамгаалах бодлого”, “Аймгийн уул уурхай, эрдэс баялгийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө”, “ХАА-г байгаль цаг уурын өөрчлөлт, зах зээлийн харилцаанд зохицуулан хөгжүүлэх төлөвлөгөө”, “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2009-2012 оны төлөвлөгөө”, “Орон сууц дэд хөтөлбөрийг 2009-2010 онд хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Хууль эрх зүйн сургалт сурталчилгааны ажлын төлөвлөгөө”, “Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Биеийн тамир спортыг хөгжүүлэх төлөвлөгөө”-г нэмж батлуулан, “Төв аймгийн хөгжлийн хөтөлбөр” болон салбаруудын хөгжлийг хангахаар өмнө гаргасан бодлого, шийдвэрүүдийн хэрэгжилтийг биелүүлэх ажлыг хяналт шинжилгээ үнэлгээгээр дэмжин ажиллалаа.

1. Санхүү, эдийн засгийн хүрээнд:

Банк, банк бус санхүүгийн байгууллагуудаас 37345 иргэнд 22.6 тэрбум төгрөгийн зээл олгож, үүнээс 2401 иргэнд 5.2 тэрбум төгрөгийн зээлийг бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд зориулан олгов. ЖДҮ-ийг дэмжих сангаас 164 төсөлд 1.1 тэрбум төгрөгийн зээл олгож, бүс нутгийн хөрөнгө оруулалтаас хөдөөгийн сум бүрд “Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-г 17.0 сая төгрөг, Зуунмод суманд 91.0 сая төгрөгийн эх үүсвэртэй байгуулж үйлдвэрлэл үйлчилгээг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлээ.

Төсвийн өр барагдуулахад боловсролын салбарын байгууллагуудад 321.0 сая төг, Эрүүл мэндийн төсвийн байгууллагуудад 69.0 сая төгрөгийн санхүүжилт олгож 2009 оны жилийн эцэст төсвийн нийт өрийг 75.8 хувиар, авлагыг 24.6 хувиар буурууллаа.

2009 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсвийн орлогод 2.7 тэрбум төгрөг оруулахаас 1.8 тэрбум төгрөг оруулж 67.83 хувиар, аймгийн төсөвт 5.6 тэрбум төгрөг оруулахаас 4.8 тэрбум төгрөг оруулж 85.47 хувиар, Улсын төсвийн орлогод 1.3 тэрбум төгрөг оруулахаас 1.34 тэрбум төгрөг оруулж 102.72 хувиар тус тус биелүүлж 3 шатны орлогын төлөвлөгөө дүнгээрээ 82.8 хувиар биелсэн нь Заамар суманд үйл ажиллагаа явуулж байсан Алтан-Дорнод Монгол ХХК-ий үйл ажиллагаа зогссон тул тус компаниас оруулахаар төлөвлөсөн алт, усны нөөцийн төлбөрийн 2.2 тэрбум төгрөг, 2009 оны 7-р сараас мал бүхий иргэний орлогын албан татварыг чөлөөлснөөс 93.0 сая төгрөгөөр тасарсан давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалсан тул УТЕГ-аас энэ дүнг хасч тооцсон байна.

2. Дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд:

2009 онд аймгийн хэмжээнд 9.8 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын ажил хийв.

Хот, сум суурин газруудад нийгмийн салбарын барилга байгууламжийг барьж, засварлах ажлын хүрээнд аймгийн нэгдсэн эмнэлгийн Халдвартын эмнэлэг, ГХБХБГазар, БСГазар, Баян, Заамар сумын Соёлын төв, Эрдэнэ сумын Мэргэжлийн сургалттай сургуулийн дотуур байр, Батсүмбэр сумын цэцэрлэгийн барилгыг шинээр барьж, Батсүмбэр сумын сургууль, Эрдэнэсант сумын цэцэрлэгийн өргөтгөл, аймгийн Биеийн тамир, спорт урлагийн цогцолбор, Баян сумын спорт заалыг барьж байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн гараж, Алтанбулаг сумын Соёлын төв, Баянжаргалан, Өндөрширээт, Борнуур сумын дотуур байр, Заамар, Баян, Баянцогт, Жаргалант сумын хүн эмнэлгийг засварлав.

Орон нутгийн авто зам, гүүр барих, засварлах, тэмдэгжүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийж, Сүмбэр сумыг төв замтай холбосон асфальто бетонон зам, Зуунмод хотын төвийн асфальто бетонон зам, Аргалант сумын төвд төмөр бетон хоолой, Батсүмбэр сумын Баянголын гүүрийг барьж, Угтаалцайдам сумын гүүрийг засварлан ашиглалтанд оруулсан.

ЖДҮ-ийг хөгжүүлэхээр улс орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалтаар Батсүмбэр суманд хүнсний ногоо дахин боловсруулах цех, Борнуур, Сүмбэр сумдад сүү цагаан идээ боловсруулах цех, Баянчандмань суманд шахмал түлшний цех, Жаргалант суманд “ХААН-Ембүү” ХХК-н сүүлийн үеийн шинэ технологитой хоногт 5-10 тн сүү боловсруулах үйлдвэр ашиглалтанд орж, Сэргэлэн суманд БНХАУ-ыг хөрөнгө оруулалттай, жилд 1 сая тн улаан цемент үйлдвэрлэх хүчин чадалтай Улаан цементийн үйлдвэр, Чех улсын тусламжаар мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр баригдаж эхлэн, тоног төхөөрөмжөө татан аваад байна.

Орон нутгийн онцлогт тохирсон экологийн цэвэр сүү, цагаан идээ, мах махан болон гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ногоо савлах жижиг цех байгуулахыг дэмжин нийт 59 төсөлд ЖДҮ-ийг дэмжих сангаас 415.0 сая төгрөгийн зээл олгов.

Худалдаа үйлчилгээний таатай орчин, хэрэглэгчид хүрсэн үйлчилгээг бий болгох зорилгоор 2223 жижиг бизнес эрхлэгчдэд банк, банк бус санхүүгийн байгууллагаас 3.9 тэрбум гаруй төгрөгийн зээл олгосон. ЖДҮ-ийг дэмжих сангаас үйлчилгээний чиглэлийн төсөлд 23 төсөлд 133 сая төгрөгийн зээл олгосноос 8 сумын 21 оёдлын төсөлд 118 сая төгрөг, ахуйн үйлчилгээний 2 төсөлд 15.0 сая төгрөгийн зээл олгож үйл ажиллагаа нь эхлээд байна.

МХГазар, Иргэний нийгмийн байгууллага хамтран 21 суманд 352 худалдаа, үйлчилгээний цэг салбарт үзлэг шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг засуулж, холбогдох арга хэмжээ авч ажилласны үр дүнд худалдаа үйлчилгээний стандарт дунджаар 78.9%-д хүрлээ.

3. Хөдөө аж ахуйн хүрээнд:

Мал эмнэлгийн анхан шатны нэгжийн үйл ажиллагааг дэмжин, улсын стандартыг 64 мал эмнэлгийн нэгжээр хангуулж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 20 нэр төрлийн арга хэмжээнд 1.8 сая мал, угаалга тарилга туулгалтанд 2.2 сая мал хамруулж, улсын төсвийн хөрөнгөөр 6 худаг, УИХ-ын гишүүдийн багцаас Бүс нутгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтаар 42 худаг шинээр гаргуулан, 2678.1 мянган га бэлчээр усжуулан, бэлчээр усжуулалтыг 49.49 %-д хүргэсэн нь Мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах гол хүчин зүйл болж, 2009 онд 1.2 сая төл бойжуулж, малын тоо толгой 3.4 саяд хүрч таван төрөл дээрээ өссөн.

Сум дундын отрын бүс нутгийн хамгаалалт, ашиглалтыг сайжруулах аймгийн бодлого гарган мөрдөж, Малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн нийт 1548 га-д тариалалт хийж, ногоон тэжээл 3230.0 тн-ыг хураан авлаа.

Мах, сүү болон бусад ашиг шимийн чиглэлийн мал, амьтад үржүүлдэг аж ахуй, фермер 2009 онд Сүүний үхрийн-146, махны үхрийн-8, гахайн-36, шувууны-28, туулайн-2, зөгийн-9, мах ноосны хонины-1, нийт 230 фермерийн аж ахуй эрхэлж, нэгжийн ашиг шимийн гарц, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэв.

“Атрын гурав дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн иргэн, аж ахуйн нэгжүүд шинээр талбай эзэмшсэнээр өнгөрсөн оноос аж ахуй нэгж, иргэдийн тоо 167, талбайн хэмжээ 32804.7 га-аар нэмэгдсэн. Аймгийн хаврын тариалалт, намрын ургац хураалтын үед баримтлах технологийг мөрдүүлж, шаардлагатай сумдад услалтын системийг засварлаж шинэчлэн усалгаатай тариалангийн талбайг 2130 га-д хүргэлээ.

Газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа 1612 өрх, аж ахуйн нэгж 44052 га-д үр тариа, 3454 га-д төмс, 1061 га-д хүнсний ногоо тариалж, үр тариа 66995 тн, төмс 40068 тн, хүнсний ногоо 10960.2 тн-ыг хураан авсан нь газар тариаланд улаан буудайн үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг нэмэгдэж улсын хэмжээний үр тарианы 20.9%, аймгийнхаа гурилын хэрэгцээг бүрэн хангахуйц 25684 тн буудайг гурилын үйлдвэрт тушааж, төмсний хэрэгцээг 5 дахин, хүнсний ногооны хэрэгцээг 1.4 дахин илүү хангаж, 2012 онд хүрэхээр дэвшүүлсэн зорилтоо давуулан биелүүллээ.

2009 онд сум бүрийг Агропарктай болгосны үр дүнд хамгаалагдсан хөрсний аж ахуй эрхлэх талбайн хэмжээ 56.0 мянган кв метрт хүрч, иргэд нарийн ногоо тарих арга технологид суралцан, 226.4 тн ургац хураан авсан. Мөн 620 тн-ны багтаамжтай 25 зоорь шинээр барьж, төмс хүнсний ногоо хадгалах 19246 тн-ны багтаамж бүхий 1641 зоорь ашиглагдаж, 48 худаг шинээр гаргаж 2678.1 мянган га бэлчээр усжуулсан.

Аймгийн эдийн засгийн гол салбар хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд ихээхэн өсөлт гарснаар аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 172.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 22.8 хувиар өсөхөөр тооцогдож байна.

4. Нийгмийн хөгжлийн хүрээнд:

Багш нарын тогтвортой ажиллах, тасралтгүй хөгжих орчинг бүрдүүлж, ажиллах нөхцлийг сайжруулснаар аймгийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын мэргэжлийн багшийн хангалт 79.4%, ЕБС-ийн мэргэжлийн багшийн хангалт 98.8%-тай болж өмнөх оноос 0.1-1.5 хувиар тус тус өссөн.

2009-2010 оны хичээлийн жилд 6 настай хүүхдийн хамрагдалт 82%, суурь боловсролын хамран сургалт 80.3% байгаа нь улсын дунджаас 9-10.7% доогуур байна.

Аймгийн хэмжээнд сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн 30, хувийн хэвшлийн 3 сургуулийн 26 нь 1-5 дугаар ангийн сурагчдад 7 хоногт 1-5 удаа халуун хоолоор үйлчилж, Алтанбулаг сумын сургуульд Тайландын “Гүнжийн сан”-ийн төслөөр “Үдийн хоол” хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн.

Ерөнхий боловсролын 25 сургууль ширээ сандлынхаа 33.6 хувийг шинэчлэн засварлаж нийт 257.453.2 мянган төгрөг, 18 дотуур байр хөнжил, гудас, цагаан хэрэглэлийнхээ 48.7 хувийг, 9 дотуур байр тасгийн сандал, орны 39.5 хувийг, дотуур байрны гал тогооны тоног төхөөрөмжөө 11 сургууль 59.1 хувийг шинэчилсэн нь нийт дотуур байрны 39.2 хувийг эзэлж байна. ЕБС-ийн 26 дотуур байрны 10 нь буюу 37 хувь нь халуун усанд орох боломтой болж, 16 дотуур байр нь шинээр 119 суултуур бүхий стандартын бие засах газартай болсон.

2009 онд 21 соёл, урлагийн байгууллага хандив, төсөл, хөтөлбөр, төсвийн хөрөнгө оруулалтаар 73173.3 мянган төгрөгний хөгжим, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдан орчин нөхцлөө сайжруулав.

Соёлын төвийн эрхлэгч нар 100%, хөгжмийн багш нарын 34.6%, сум, сургуулийн номын санчдын 25% нь мэргэжлийнх байна. Соёл, урлагийн байгууллагыг мэргэжлийн боловсон хүчнээр хангах зорилгоор 2009-2010 оны хичээлийн жилд СУИС-ийн мэргэжлийн дипломын зэрэг олгох эчнээ сургалтанд 7 соёлын төвийн эрхлэгч, Соёлын дээд сургуульд 8 сумын соёлын ажилтанг суралцуулж байна.

Аймгийнхаа 8 сум, 8 аймгийн 30 суманд театрын урлагийн бригад явж 20700 хүнд үйлчиллээ. Д.Нацагдорж, Б.Дамдинсүрэн нарын “Учиртай гурван толгой” дуурь, Ч.Ганхуяг, Д.Бямбабаяр нарын “Зүүд шиг хайрын тухай үлгэр” моно опер болон 3 концерт шинээр найруулан тавихад 17.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв.

Орон нутаг, иргэдийн санаачилгыг дэмжин, иргэдийг төсөл хөтөлбөрт хамруулж газар тариалан, өрхийн үйлдвэрлэл-үйлчилгээг өргөжүүлж ажилласны үр дүнд 2089 иргэнийг сул чөлөөтэй ажлын байранд зуучилсны 963 нь бүртгэлтэй ажилгүйчүүд байгаа бөгөөд, 2007 ажлын байрыг шинээр бий болголоо.

Ажилгүйдлын түвшин 1.2 хувь болсон нь улсын дунджаас 2.3 дахин бага байна.

18 сум ядуурлаас гаргах өрхүүдээ сумын удирдах албан тушаалтан, албан байгууллагад хариуцуулж, сум бүрийн онцлогийг харгалзан боломжтой гэж үзсэн үзүүлэлтүүдээр амьжиргааны түвшинг тодорхойлоход 75% нь буюу 357 өрхийн амьжиргаа дээшилсэн дүнтэй байна.

2009 онд бүх төрлийн тэтгэвэр тэтгэмжийг сар бүр хугацаанд нь санхүүжүүлж, 10426 тэтгэвэр авагчдад 11048.1 сая төгрөг олгосон.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогоор 5868.0 сая төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 101.5 хувь биелүүлэв. Эрүүл мэндийн даатгалд 11850 иргэнийг хамруулахаас 11916 иргэн хамруулж, 73.0 сая төгрөгийн хураамжийн орлого орууллаа.

Эхийн эндэгдлийн 3 тохиолдол, Нялхсын эндэгдлийн 17 тохиолдол гарч амьд төрсөн 1000 хүүхдэд 18.26 промилль буюу өнгөрсөн оны мөн үеэс 10.64 промиллоор өссөн боловч Мянганы хөгжлийн зорилтод түвшингээс 3.74 промиллоор доогуур үзүүлэлттэй байна.

Нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг оношлогоог 26 суманд явуулж, зүрх судас, мэс засал, эмэгтэйчүүд, шүд, нүд, хүүхэд, цус, чих хамар хоолой, дотор, БЗДХ, мэдрэл, сутгэц, дүрс оношлогоо, статистикийн чиглэлээр 15 их эмч, 3 лаборант ажиллаж, нийт 12695 хүнд үзлэг хийж, 3415 хүнийг шинжилгээнд хамрууллаа.

“Цаасгүй эмнэлэг” төслийг аймгийн нэгдсэн эмнэлэгт үе шаттай хэрэгжүүлэн, “Цахим бүртгэл”-д шилжиж, “Алсын зайн оношлогооны төв”-ийг байгуулахаар эхний ээлжинд АНЭ-ийн 68 компьютероос 55-г дотоод сүлжээнд холбож, шилэн кабель татан, өрх, хүн амын эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдүүлэв. “E-hospital” програмд үйлчлүүлэгчдийн цахим бүртгэлийг оруулж, нарийн мэргэжлийн кабинетуудын 44.5%-ийг сүлжээний горимд ажиллуулж байна. АНЭ, хөдөөгийн сумдаас Эрдэнэ сумын эмнэлэг дотоод сүлжээ болон Шастины нэрэмжит III эмнэлэгтэй холбогдон зөвлөгөө авах, алсын зайн оношлогоо хийлгэх боломжтой боллоо.

5. Байгаль орчны хүрээнд:

Байгаль орчныг хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлж 24 сумын багийн ИНХ-аар хэлэлцүүлэн 78 идэвхтэн байгаль хамгаалагч сонгон томилж, ой бүхий Эрдэнэ, Жаргалант, Батсүмбэр, Мөнгөнморьт, Баяндэлгэр, Баянцогт суманд 45 нөхөрлөл үйл ажиллагаа явуулж байна.

Лүн суманд Ногоон хэрэм үндэсний хөтөлбөрийн хүрээнд ойн зурвас байгуулахад шаардлагатай навчит модны суулгац ургуулах мод үржүүлгийн газрыг 20 га талбайд байгуулан 2009 онд 200.0 мянган ширхэг мод үржүүлэв.

2009 онд уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулах хүсэлт ирүүлсэн 14 аж ахуйн нэгж, байгууллагатай 102 га талбайд техникийн, 69.9 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийх гэрээ байгуулсны дагуу 343.2 га талбайд техникийн, 24.9 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг хийлгэв.

2009 онд аймгийн хэмжээнд Заамар, Сэргэлэн, Алтанбулаг, Баян, Баянжаргалан, Баяндэлгэр, Эрдэнэ, Мөнгөнморьт, Борнуур, Жаргалант, Сүмбэр, Баянчандмань сумын нийт 69 аж ахуйн нэгж, гар аргаар алт олборлогч иргэд орсон талбайг хамруулан уул уурхайн зориулалтаар хөндөгдсөн газрын тооллого хийлээ.

“Аймгийн хэмжээнд уул уурхай, эрдэс баялагийн талаар баримтлах бодлого”-д тусгагдсан ашигт малтмалын нөөц багатай, аймгийн хөгжилд онц нөлөөлөлгүй, эдийн засагт ашиг муутай стратегийн бус ордыг ашиглуулахгүй байх бодлого баримталж байна.

2009 онд 173.6 мянган га газар нутагт хайгуулын тусгай зөвшөөрөл авахыг хүссэн 114 аж ахуйн нэгжийн хүсэлт ирснийг судалж 113 аж ахуйн нэгжид саналыг дэмжих боломжгүй гэсэн хариу өгч Бүрэн сумын нутагт 1 аж ахуйн нэгжид 4693 га газарт хайгуул хийх боломжтой гэсэн санал гаргасан.

Аймгийн хэмжээнд бүх сумын төвийн хог хаягдлын төвлөрсөн цэгийг тогтоож, хашаажуулан тохижуулав.

Сумдад өмчлүүлэх газрын байршил, хэмжээг тогтоон 2009 онд сумын төв болон суурин газар, улсын чанартай авто замын дагуух газарт нийт 1772.3 га газрыг өмчлүүлэхээр төлөвлөснөөс 631 иргэн 200.38 га газрыг өмчилж аваад байна. Аймгийн хэмжээнд нийт 9824 иргэн 2711.693 га газрыг өмчлөн авч, 4912 иргэн 922.8 га газрыг өмчилж авснаа улсын бүртгэлд бүртгүүлэн батлагаажуулсан.

Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг 2 экспедицийн бүрэлдхүүнтэйгээр нийт 39 удаагийн харвалт хийж, аймгийн нутгийн ихэнх хэсгээр 5-8 дугаар сард олон

жилийн дунджаас 0.1-142.3 мм-ээр хур тунадас нэмэгдэн орж, зуншлага, ургацанд эерэг нөлөө үзүүлээ.

6. Нутгийн захиргаа, хууль хяналтын хүрээнд:

Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах төрийн албан хаагчдын чадавхийг бэхжүүлэх, төр засгийн тогтоол шийдвэрийн биелэлтийг орон нутагт зохион байгуулах ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор сумдын ажил дүгнэх журмыг шинэчлэн урамшуулал-хариуцлагын тогтолцоо бүрдүүлэн, аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийг 2 удаа явуулж, салбарын чиглэлээрх 19 үзүүлэлтийг нэмж сумын ажлыг хагас бүтэн жилээр дүгнэж ажиллав.

Аймгийн ЗДТГазрын хэлтэс, Засаг даргын дэргэдэх агентлаг, аймгийн харьяа байгууллагын үйл ажиллагааг улирал бүр дүгнэн, үйл ажиллагааны явцын хяналт шинжилгээ үнэлгээг Иргэд, иргэний нийгмийн байгууллагатай хамтран хийх журам гаргаж, Иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн хөндлөнгийн үнэлэлт дүгнэлтээр Хяналт шинжилгээ үнэлгээг ханган ажиллаж байна.

Төрийн албаны ил тод, нээлттэй байдлыг ханган Төрийн албаны мэргэшлийн шалгалтыг 2009 онд 2 удаа авч, шалгалтанд тэнцэн нөөцөд бүртгэгдсэн 194 хүнээс онооны дарааллаар сул ажлын байранд 40 хүнийг томилов.

УБХэлтэс болон Зуунмод сум нь УБЕГазрын онлайн сүлжээнд холбогдож, “Нэг цэгийн үйлчилгээ”-ий танхимд УБХэлтсийн шилжилт хөдөлгөөн, бүртгэлийн мэргэжилтэн, хаягийн санч, Зуунмод сумын ЗДТГ-ын иргэний бүртгэлийн үйл ажиллагааг бүрэн хамруулан иргэдэд үйлчилгээг шат дамжлагагүй, шуурхай хүргэж байна.

Угтаалцайдам, Батсүмбэр, Баянцогт, Баянхангай, Баянцагаан, Баянжаргалан, Сэргэлэн, Баянчандмань, Зуунмод, Баяндэлгэр, Борнуур, Эрдэнэ, Мөнгөнморьт сумдад ХАА, Байгаль орчин, Газар, Нийгмийн халамж, Нийгмийн даатгал, Татвар, Иргэний бүртгэлийн үйлчилгээг төвлөрүүлэн, иргэдэд үйлчлэх ая тухтай орчин бүрдүүлсэн “Нэг цэгийн үйлчилгээ”-ий танхим шинээр нээж, үйл ажиллагаагаа тогтмолжуулаад байна.

НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн Засаглалыг дэмжих хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын оролцоо дэмжлэгтэйгээр амжилттай хэрэгжүүлж, 27 суманд ОНИМТөв байгуулснаар мэдээ мэдээлэл цахим хэлбэрээр дамжуулан, иргэд мэдээ мэдээллийг ил тод, шуурхай авах боломж бүрдсэн.

Багийн төвийг тохижуулах, шинээр байгуулах ажлын хүрээнд өмнө оны дутуу гүйцэтгэлтэй байсан Эрдэнэ сумын Хушинга баг, Баянжаргалан сумын Эрдэнэ, Архуст сумын Нарст, Баян сумын Өгөөмөр, Алтанбулаг сумын Замт багийн төвийг орон нутгийн нөөц бололцоог ашиглан барьж ашиглалтанд оруулж, Баянжаргалан сумын Жаргалант багт багийн төв шинээр барьж, Баян сумын Цант баг конторын барилга худалдаж авсан.

Аймгийн гадаад харилцаа бүх талаар хөгжиж, Япон, БНСУ, БНХАУ зэрэг 10-аад орны муж, районуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн ажилласны үр дүнд аймагт 1 тэрбум орчим төгрөгийн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажил хийгдэв. Уул уурхайн чиглэлээр ашиглагдсан хөрс нөхөн сэргээх, хөрс сайжруулах, ургамлын суулгац ашиглан ойжуулах чиглэлээр БНСУ-ын MIRECO корпорацитай 2009 онд хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж, Зуунмод хотод 300 га газарт байгуулах Мод үржүүлгийн цогцолбор байгуулахаар болсон. Аймгийн төрийн албан хаагч 40 орчим хүн, 140-өөд оюутан, хүүхэд залуусыг солилцооны хөтөлбөр, олон улсын чанартай арга хэмжээнд оролцуулж оюуны хөрөнгө оруулалт хийж байна. АНЭ-т Япон улсын тусламжаар эмч нарыг нарийн мэргэшлээр аймагт болон Тоттори мужид мэргэшүүлэх сургалт зохион байгуулахаар шийдвэрлэв.

Аймгийн хэмжээний төрийн байгууллага, албан тушаалтанд 22271 өргөдөл, гомдол ирснийг хүлээн авч хугацаанд нь хариуг өгсөн байна.

Иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргаас гачигдалтай 52 иргэнд 8.4 сая төгрөгийн тусламж, тэтгэмж, аймгийн ЗДТГ-ын Хөдөлмөрийн дотоод журмын дагуу 11 хүнд 580.0 мян төгрөгийн тусламж үзүүллээ.

Албан хэрэг хөтлөлтийн иж бүрэн програмыг бүх сумдад нэвтрүүлж, архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт 95.2% дүгнэгдсэн.

Зуунмод ТВ-ийг аймгийн Олон нийтийн TBS телевиз болгон өргөжүүлж аймгаас 22.7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, 6 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна. TBS телевиз өөрийн дамжуулах станц, сувагтай болж, Зуунмод сумын бүх өрхөд нэвтрүүлэг хүргэдэг болсон. TBS телевиз иргэдийн дуу хоолойг сонсох, мэдээ мэдээллийг иргэдэд шууд хүргэх асуудал дэвшүүлсэн “Гүүр”, “Индэр” зэрэг шууд нэвтрүүлгийг тогтмол явуулж байна.

Гамшгаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, сумдад гамшгийн үед шаардлагатай хүнс, шатахууны нөөцийн гэрээг 500.0-2500.0 мянган төгрөгөөр тодотгон шинэчилж, аймаг, сумын хэмжээнд хүнс, шатахууны нөөцийг тухайн орон нутаг дахь худалдаа үйлчилгээний төв, ШТСтанцуудтай гэрээ хийж нөөц бүрдүүлэн ажиллаж байна. Аймгийн Засаг даргын нөөц сангаас хөрөнгийг шийдвэрлэж Лүн суманд 3000 боодол өвс бүхий аймгийн өвс, тэжээлийн цэгийг байгуулж зэргэлдээх 8 суманд үйлчлэх гамшгийн үеийн нөөцийг бүрдүүлсэн.

ОБЕГазрын команд штабын сургуульд аймаг, сумын Онцгой комиссын гишүүд, сумдын хүн, малын эмнэлгийн эрхлэгчид, хөдөө аж ахуйн мэргэжилтэн, байгаль орчны хяналтын улсын байцаагч, нийт 195 удирдах ажилтан, албан хаагч, гамшгаас хамгаалах 8 алба, 16 мэргэжлийн ангийн 160 томилгоот бүрэлдэхүүн, нийт 300 гаруй хүн хамрагдаж, “Хангалттай” үнэлгээ авсан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд хууль сахиулах болон иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хамтын ажиллагааг уялдуулан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 2009 онд 865272.4 мянган төгрөгийн хохиролтой 690 гэмт хэрэг үйлдэгдсэнээс 30.4 хувь нь хулгайн гэмт хэрэг, 45.7 хувь нь мал хулгайлах гэмт хэрэг үйлдэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 56.6 хувиар буурлаа.

Нийгмийн хэв журам хамгаалах ажлыг эрчимжүүлж орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн Баянхангай, Эрдэнэ, Лүн, Эрдэнэсант, Баян, Баянчандмань сумдын цагдаагийн постуудад болон аймгийн Цагдаагийн газар хөдөлгөөнт эргүүлийн зориулалтаар тоноглогдсон автомашинтай болж, Зуунмод суманд хөдөлгөөнт эргүүл тогтмол ажиллаж байна.

Зуунмод сумын төвийн 3 өндөрлөг цэгт Wireless системийн хяналтын видео камер байрлуулан, Цагдаагийн газраас 24 цагийн турш хяналт тавин ажилласнаар гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 30.3 хувиар буурав.

Төрийн байгууллагуудаас иргэдэд төрийн үйлчилгээг сурталчлах, түргэн шуурхай хүргэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, иргэдийн өргөдөл хүсэлтийг шийдвэрлэх, санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгах зорилгоор “Нээлттэй хаалганы өдөр”, “Нээлттэй өдөрлөг”-ийг 27 сумын хэмжээнд улирал бүр зохион байгуулж, иргэдтэй уулзалт ярилцлага хийн, санал бодол, хүсэлтийг нь хүлээн авч, түүний мөрөөр сум аймагт төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг зохион байгуулж эргэж мэдээлэх зэргээр ард иргэдийнхээ санал хүсэлтийг бодлого үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж ажиллалаа.

III. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ҮР ДҮН

2009 онд шинээр нийт 97 шийдвэрийг хяналтанд авч, Засгийн газрын нийт 106 тогтоолын 196 заалт, Засгийн газрын хуралдааны 24 тэмдэглэлийн 32 заалт, Ерөнхий сайдын 1 захирамж, Шадар сайдын 1 тушаалын 2 заалт, Засгийн газрын 6 албан даалгаварын 29 заалт, нийт 138 шийдвэрийн 260 заалтыг 5 хэлтэс 20 агентлаг, харьяа 5 байгууллагад хяналтын картаар хариуцуулан өгч ажиллав. 2009 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын 123 шийдвэрийн 225 заалтын хэрэгжилт 89,1%-тай. Үүнээс ЗГ-ын тогтоол 88.05%, хуралдааны тэмдэглэл 92.8%, Ерөнхий сайдын захирамж 100.0%, ЗГ-ын албан даалгавар 93.57%, Шадар сайдын тушаал 100.0%-ийн хэрэгжилттэй байна.

Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх зорилгоор 30 байгууллагад явцын хяналт, улирал бүр хяналт шинжилгээ үнэлгээ хийн дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал болон байгууллагын мэдээллийн цагаар мэдээллээ. Мөн хэрэгжилтүүдийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэрийн хэрэгжилт болон хөтөлбөрийг эрчимжүүлэх талаар аймгийн Засаг даргын захирамжаар өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилтийг тооцож ажиллав. Засгийн газрын тогтоол шийдвэр, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг нийтэд мэдээлэх зорилгоор аймгийн веб сайтад мэдээлэл тавилаа.

Тайлант хугацаанд Засгийн газрын 23 тогтоолын 51 заалт, хуралдааны 6 тэмдэглэлийн 9 заалт, Ерөнхий сайдын 2 захирамж, Засгийн газрын 5 албан даалгаварын 27 заалт хэрэгжилт нь бүрэн хангагдаж үйл ажиллагаа нь тогтмолжсон тул хяналтаас хаслаа.

“Төсвийн гүйцэтгэлийн сахилга, хариуцлагыг чангатгах зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын 2006 оны 58-р тогтоолын хүрээнд: “Төвлөрсөн төсөвт болон орон нутгийн санхүүжилттэй бүх төсөвт байгууллагуудыг өр авлагаа тооцоо нийлсэн актаар үнэн зөв баталгаажуулан тайлан балансад тусгуулах шат дараалсан арга хэмжээ авсан. Сум, төсөвт байгууллагуудын төсвийн санхүүжилтийг батлагдсан төсвийн зарцуулалтын эрхийн хүрээнд төрийн сангаар дамжуулан гүйлгээнд хяналт тавин ажиллав. БСШУСайдын багцын төсвийн байгууллагуудын халаалтын зардалд үүссэн 240.5 сая төгрөгийг журмын дагуу эрх авч, Эрүүл мэндийн салбарт үүссэн 67.0 сая төгрөгийн өрийг тус тус барагдуулав. Орон нутгийн төсвийн байгууллагуудад 11 сарын байдлаар үүссэн 75.0 сая төгрөгийн өрийг Сангийн яаманд тавьж шийдвэрлүүлэн аймгийн Засаг даргын 2009 оны 573 тоот захирамжаар сум, төсөвт байгууллагуудад хуваарилан олгосон. Эдгээр үйл ажиллагааны дүнд 2008 оны эцэст авлага 144,1 сая төгрөг байсан бол 2009 оны жилийн эцсийн байдлаар 85.56 сая төгрөг болж 58.54 сая төгрөгөөр, өр төлбөр 2008 оны жилийн эцэст 229.8 сая байснаас 55.49 сая төгрөг болж 174.31 сая төгрөгөөр буурлаа.”

“Суралцагч байгууллагыг хөгжүүлэх манлайлал” сэдэвт сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай 2007 оны 168-р тогтоолын хүрээнд: МУ-ын Засгийн газар, Төрийн албаны зөвлөл, Шведийн Төрийн захиргааны олон улсын институт хамтарсан “Суралцагч байгууллагыг хөгжүүлэх манлайлал” сэдэвт ерөнхий менежерүүдийн шаталсан сургалтын эхний үе шат 2007-2008 онд хэрэгжсэн бөгөөд үүнд аймгийн төв Зуунмод хотын болон Эрдэнэ, Архуст, Мөнгөнморьт сумдын 40 орчим ерөнхий менежерүүд хамрагдсан. 2009 онд 140 орчим ерөнхий менежерийг 3 үе шаттайгаар Борнуур, Зуунмод, Эрдэнэ суманд тус тус бүсчилэн хийв. 2 дахь шатны сургалтад бусад 23 сумын төсвийн ерөнхий менежерүүд хамрагдаж тэдний удирдах, манлайлах ур чадварыг дээшлүүлсэн. Тус сургалтанд 27 сумын 160 гаруй төсвийн ерөнхий менежер болон зарим сумдын шинээр томилогдсон ИТХ-ын дарга, ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бүрэн хамрагдсан. **“Төсөл хэрэгжүүлэх тухай” 2008 оны 13-р тогтоолын хүрээнд:** “Агропарк төслийн хүрээнд 2009 онд сум бүрийг Агропарктай болгож, хамгаалагдсан хөрсний аж ахуй эрхлэх талбайн хэмжээ 56.0 мянган кв метрт хүрч, иргэд нарийн ногоо тарих арга технологид суралцан, 226.4 тн

ургац хураан авсан. Мөн 620 тн-ны багтаамжтай 25 зоорь шинээр барьж, төмс хүнсний ногоо хадгалах 19246 тн-ны багтаамж бүхий 1641 зоорь ашиглагдаж, 48 худаг шинээр гаргаж 2678.1 мянган га бэлчээр усжуулаад байна.”

Монгол Улсын Засгийн газраас баталсан Үндэсний хөтөлбөрүүдийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор өөрийн аймгийн онцлогтой уялдуулан, салбар хариуцсан мэргэжилтнүүдийн хийсэн судалгаа, дүгнэлтэнд тулгуурлан бодлого зохицуулалтын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, явцад нь хяналт шинжилгээ хийж үр дүнд хүргэхэд аймгийн ЗДТГ анхаарч ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 2009 онд төрийн захиргааны чиглэлээр 3, онцгой байдлын хүрээнд 1, мэргэжлийн хяналтын хүрээнд 1, эрүүл мэндийн салбарт 9, боловсролын салбарт 8, хүнс, хөдөө аж ахуйн хүрээнд 10, үйлдвэр дэд бүтцийн хүрээнд 18, нийгмийн хөгжил, хамгааллын хүрээнд 8, байгаль орчин, газар, цаг уур, орчны шинжилгээнд 14, хууль зүйн хүрээнд 10 нийт 82 үндэсний хөтөлбөр, аймгийн дэд хөтөлбөр 19, төлөвлөгөө 13, бодлого 6-г хяналтанд авч хэрэгжилтийг ханган ажиллаа.

Үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц 2009 оны жилийн эцсийн байдлаар 91.60%-тай байна.

IV. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРТЭЙ БАЙГУУЛСАН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

2009 онд бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээний биелэлтийг бүтээгдэхүүн тус бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /тоо хэмжээ, чанар, хугацаа, өртөг/-ийн болон хүрэх үр дүнгийн хэрэгжилтийг хагас жил, жилийн эцсийн байдлаар гаргаж аймгийн Засаг даргаар ажлаа дүгнүүллээ.

Жилийн эцсийн байдлаар нийлүүлбэл зохих нийт 13 бүтээгдэхүүнд авбал зохих 30 онооны 30, тусгай захиалгат 1 бүтээгдэхүүнд авбал зохих 40 оноо, өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх 5 бүтээгдэхүүнд авбал зохих 30 оноог авч нийт авбал зохих 100 оноо авч, “А” буюу “маш сайн” үнэлгээ авлаа.

Аймгийн ЗДТГ-ын Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээнээс аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2009 оны Үндсэн чиглэлд тусгагдсан зорилтууд, захиргааны удирдлага зохицуулалт, захиргааны стандартын хангалт, гадаад харилцаа хамтын ажиллагаа, мэдээллийн технологи сүлжээний ашиглалт, захиргааны дотоод зохицуулалт, иргэд олон нийттэй харилцах, иргэдийн санал, өргөдөл гомдлыг шийдвэрлэх болон өмчлөлийн зорилтыг хангахад чиглэсэн бүтээгдэхүүнүүд бүрэн хангалттай хэрэгжлээ.

V. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ /САЙД/ НАРААС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Бүтээгдэхүүний ангийн тоо	Үүнээс тасарсан	Биелэлтийн дундаж хувь	Оноо	Үнэлгээний коэффициент	Үнэлгээний оноо
46	-	95,8	4.79	1.0	4.79

Төсвийн ерөнхийлөн захирагч /10 яамны сайд/ нараас аймгийн Засаг даргатай 2009 онд байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээгээр 46 ангийн бүтээгдэхүүн нийлүүлэхээс 46- г нийлүүлж, тасарсан бүтээгдэхүүний анги байхгүй.

Салбарын яамдын сайдуудтай байгуулсан гэрээний биелэлтийг авч үзэхэд Батлан хамгаалахын сайдын 4 бүтээгдэхүүний анги 95%, БСШУ-ны сайдын 9

бүтээгдэхүүний анги 99,4%, ЭМ-ийн сайдын 4 бүтээгдэхүүний анги 92,5%, НХХ-ийн сайдын 5 бүтээгдэхүүний анги 96,84%, Монгол улсын Шадар сайдын 6 бүтээгдэхүүний анги 97,2%, Тэргүүн шадар сайдын 1 бүтээгдэхүүний анги 98,4%, Байгаль орчны сайдын 3 бүтээгдэхүүний анги 94,5%, ХХААХҮ-ийн сайдын 5 бүтээгдэхүүний анги 95,2%, ХЗДХ-ийн сайдын 5 бүтээгдэхүүний анги 93,3%, Үндэсний статистикийн газрын 4 бүтээгдэхүүний анги 95 хувийн хэрэгжилттэй байна.

Үр дүнгийн гэрээнээс **БХЯамны хүрээнд**: Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавих, Цэргийн үүрэгтний бүртгэл хөтлөх, сургаж, бэлтгэх, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, цэрэг татлага зохион байгуулах, цэргийн албыг дүйцүүлэн хааж буй иргэдтэй сургалт явуулах, мөнгөн төлбөрийн тооцоо хийх, Дайчилгааны төлөвлөгөөг тодотгож, баталгаажуулах, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах зэрэг 3 бүтээгдэхүүний анги, **БСШУЯамны хүрээнд**: Хөрөнгө оруулалт, их засварын үйлчилгээ, **ЭМЯамны хүрээнд**: Хөрөнгө оруулалт, их засварын үйлчилгээ, **НХХЯамны хүрээнд**: Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх үйлчилгээ, Орон нутгийн ахмадын байгууллагыг дэмжих үйлчилгээ зэрэг 2 бүтээгдэхүүний анги, **МУ-ын Шадар сайдын хүрээнд**: Байгууллага, мэргэжилтнийг чадавхижуулах, **БОАЖЯамны хүрээнд**: Ойжуулалт, ойн арга хэмжээ, **ХХААХҮЯамны хүрээнд**: Хүнс, ХАА-н байгууллагын нийтлэг үйлчилгээ, Хөнгөн, жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа, ахуйн үйлчилгээ, Хүнсний үйлдвэрлэлийг дэмжих үйлчилгээ зэрэг 3 бүтээгдэхүүний анги, **ХЗДХЯамны хүрээнд**: Өмчлөлийн эрхийг хэрэгжүүлэх, **ҮСГазрын хүрээнд**: Бодлогын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа зэрэг 14 бүтээгдэхүүний анги 100 хувь хэрэгжсэн байна.

ҮІ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР АВСАН АРГА ХЭМЖЭЭ, ҮР ДҮН

Байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах үүднээс аймгийн төвийн байгууллага бүр вэб сайттай болж түүгээрээ дамжуулан өөрсдийн үйл ажиллагааг иргэдэд тайлагнан, сурталчилж, мэдээ мэдээллээ богино хугацаанд иргэдэд хүргэж байна.

27 суманд Олон нийтийн интернэт мэдээллийн төвийг байгуулж, бүх сумд өөрийн гэсэн вэб сайттай болсон. Тус вэб сайтуудад сумын төвийн төсөвт байгууллагууд өөрийн танилцуулга, эрхэм зорилго, зорилт, албан хаагчдын хаяг, холбоо барих утас, байгууллагын дотоод дүрэм, хариуцах асуудал зэргийг байршуулж мэдээ мэдээллийг шинэчилэн ажиллаж байна.

Аймгийн вэб сайтад аймгийн Засаг даргын 2009-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг 2009 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл зэрэг томоохон бодлогын баримт бичгүүдийг байрлуулснаас гадна аймгийг ИТХ, Засаг даргаас нийтээр дагаж мөрдөхөөр гаргасан эрх зүйн акт, баримт бичиг, дүрэм журмыг байршуулж хэвшсэн.

Төсвийн байгууллагууд иргэд рүү чиглүүлсэн үйл ажиллагаа, цаг үеийн шинжтэй ажил асуудлуудаа вэб сайтад байрлуулж, 27 сум сар бүр хийсэн ажлын тайлангаа гаргаж аймгийн вэб сайтад байрлуулж иргэдийг мэдээллээр хурдан хугацаанд ханган ажиллаж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг Төрийн албаны салбар зөвлөлийн мэдээллийн самбар, аймгийн вэб сайтад байрлуулав. Аймаг, сумдын ЗДТГ-ын бүтэц өөрчлөгдсөнтэй холбогдуулан бичиг хэрэг хариуцах мэргэжилтнийг тушаалаар томилж, албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэнд хяналт тавьж ажиллав. Үүний үр дүнд иргэдийн өргөдөл гомдлыг хугацаа хэтрүүлэлгүй шийдвэрлэж, хариу өгөх асуудлыг

байнга хянаж, албан бичиг, өргөдөл гомдлыг эзэнгүйдүүлэх явдал гаргалгүй ажиллаж хэвшсэн.

Аймаг сумдын ЗДТГ-ын дарга, мэргэжилтнүүдийн нэр, албан тушаал, хариуцсан асуудал, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг өрөө болгоны үүдэнд байрлуулсан.

Төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээг шат дамжлагагүй болгох, шударга шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилгоор Зуунмод сумын ЗДТГазрын байранд Швейцарын хөгжлийн агентлаг, Үйлдвэр худалдааны яам, аймгийн ЗДТГазар, Хүний аюулгүй байдлын судалгааны төв хамтран төсөл хэрэгжүүлж “Нэг цонхны үйлчилгээ”-ний загвар байр бий болгож, НДХ, Газрын алба, ЭХУБАлба, Нотариат, ИБМА, ХХҮХэлтэс, ХААН банкны 10 гаруй үйлчилгээг үзүүлж байна. Ажиллах хүмүүсийн нэгдсэн сургалт-семинарыг зохион байгуулж, тавилга, техник тоног төхөөрөмжийг байрлуулан “Нэг цонхны үйлчилгээ”-г ажиллуулах болж, одоогийн байдлаар 70 гаруй мянган иргэнд төрийн үйлчилгээг үзүүлээд байна.

ДҮГНЭЛТ

Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны 2009 оны үр дүнгийн үнэлгээг Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу урьдчилсан байдлаар тооцож дүгнэхэд үнэлгээний оноо 4.766 байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Ц.ЭНХБАТ